



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖИД

“СТАНДАРТ НООС”

ХУВЬЦААТ КОМПАНИ

Баянхонгор аймаг, Баянхонгор сум,

1-р баг, Номгон, 0,

Утас: 99116313, 99447199

E-mail: standartnoos@gmail.com

Enkhtur_2008@yahoo.com

2026.02.09 № 01/26

танай _____-ны № _____-т

Хурлын мэдэгдэл хүргэх тухай

Стандарт ноос ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 2-р сарын 06-ны өдрийн хурлаар компанийн ногдол ашиг хуваарилах эсэх болон хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай хэлэлцэн шийдвэр гаргасан тул “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.6 дугаар заалтын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг хавсралтын хамт хүргүүлэв. Үүнд :

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл – 1 хуудас
- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай тогтоол, хавсралт – 2 хуудас
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, тооллогын комиссыг томилох тухай тогтоол – 1 хуудас
- Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх тухай тогтоол – 1 хуудас
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын нийтэд мэдээлэх зарын загвар – 1 хуудас.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загвар – 1 хуудас.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл – 2 хуудас.

Бүгд 9 хуудас материал.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт бэлэн болгох хугацаа – 2026.02.16.

Хуулбарыг : **САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БААСАНБАТ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	"Стандарт ноос" ХК
Хаяг :	Баянхонгор аймаг. Баянхонгор хот. 1-р баг. Хуучнаар бөөний бараа баазын урд талд. Компанийн байр.Утас : 95045544, 99186624
Хурал хуралдах өдөр, цаг :	2026оны 3-р сарын 24-ний өдөр. 11.00 цаг.
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	ХУД. 1-р хороо. Чингисийн өргөн чөлөө. УБ- 210136. "Улаанбаатар хивс" ХК-ийн хурлын танхим.
Хурлын төрөл	Ээлжит
	Ээлжит бус
Хурал зарлагч :	"Стандарт ноос" ХК-ийн ТУЗ.
	ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан\нэр\
	Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан\нэр\
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо :	2026 оны 2-р сарын 06-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо	2026.02.11 ба 2026.02.26-ны өдөр
Бүртгэлийн өдөр :	2026 оны 3-р сарын 02.
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо	2026 оны 2-р сарын 16.
Хүргүүлсэн огноо	.
Хурлын даргын нэр :	Ё.Энхтөр
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр :	Дарга : Б.Соёлмаа. Гишүүд : С.Баясах. . . Г.Амаржаргал
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/ :	
Баримт бичгийн хуудасны тоо :	. . . ширхэг.
	. . . хуудас.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА /..... / Л.Цэвээнравдан /

2026 оны 2 дугаар сарын 06-ны өдөр

**“СТАНДАРТ НООС” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026.02.06.

Улаанбаатар хот

Дугаар №01

Хувьцаа эзэмшигчдийн хурал
хуралдуулах тухай

Монгол улсын хууль, журмын дагуу компанийн 2025 оны үйл ажиллагаа, үр дүн гарсантай холбогдуулан Монгол улсын Компанийн тухай хууль болон “Стандарт ноос” ХК-ийн дүрмийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ТОГТООХ НЬ :

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг Хавсралт 01-ийн дагуу 2026 оны 3-р сарын 24-ны өдрийн 11.00 цагт хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрийг 2026 оны 3-р сарын 02-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохих хугацаанд нь хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, тооллогын комиссийн гишүүд, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЗОРИГТ

“Стандарт ноос” ХК-ийн ТУЗ-ийн 2026.02.06 -ны
өдрийн хурлын 01 тогтоолын Хавсралт 01.



**“Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2026 оны ээлжит хурлыг хуралдуулах тухай :**

1. Хуралдах өдөр, цаг, хаяг : “Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2026.03.24-ний өдөр \ Мягмар гариг\ 11.00 цагт хийнэ.**
Хаяг : ХУД. 1-р хороо. Чингисийн Өргөн Чөлөө. УБ-210136.
“Улаанбаатар хивс” ХК-ийн хурлын танхим.
2. **Хурлын хэлэлцэх асуудлууд :**
 - а/ “Стандарт ноос” ХК-ийн 2025 оны ерөнхий байдал, 2026 оны үндсэн зорилтын тухай
 - б/ “Стандарт ноос” ХК-ийн санхүүгийн тайлан, аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт
 - в/ “Стандарт ноос” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сонгууль
3. “Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр— **2026.03.02.**
4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам :
 - 2026.02.11 ба 2026.02.26.
 - Өдөр тутмын сонин : Өдрийн сонин, Зууны мэдээ.
5. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт : - компанийн санхүүгийн жилийн тайлан;
 - санхүүгийн жилийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлт;
 - компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
 - компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
 - компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал;
 - компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан;
 - хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх шаардлагатай бусад мэдээлэл.
6. Саналын хуудасны загвар, агуулга.
7. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр : 2026.03.24-ний өдрийн 9.00.цаг хүртэл.
8. Хурлын дарга : Ё.Энхтөр.
9. Ирц бүртгэл, тооллогын комисс :

Дарга : Б.Соёлмаа- Нягтлан бодогч.

гишүүд : С.Баясах- Маркетингийн менежер

Г.Амаржаргал- Маркетингийн мэргэжилтэн.

**“СТАНДАРТ НООС” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 .02.06.

Улаанбаатар хот

Дугаар № 02

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
дарга, тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1., 60.2., 67 дугаар зүйл болон “Стандарт ноос” ХК-ийн ТУЗ-ийн 2026.02.06-ны өдрийн хурлын хэлэлцсэн асуудал, гарсан санал, шүүмжлэлийг үндэслэн ТОГТООХ НЬ :

1. “Стандарт ноос” ХК-ийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Ёндонжамц овогтой Энхтөрийг томилсугай.
2. “Стандарт ноос” ХК-ийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц болон тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд .
Тооллогын комиссын дарга : Б.Соёлмаа.
Гишүүд : С.Баясах.
Г.Амаржаргал
3. “Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажил, хурлын ирц бүртгэл, хэлэлцэх асуудлын санал хураалтыг холбогдох хууль, журмын дагуу шударга, шуурхай зохион байгуулж ажиллахыг хурлын дарга болон тооллогын комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЗОРИГТ

“СТАНДАРТ НООС” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 .02.06.

Улаанбаатар хот

Дугаар № 03

Ногдол ашгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46.5 ба 47 дугаар зүйл, “Стандарт ноос” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнг харгалзан ТОГТООХ НЬ :

1. Стандарт ноос ХК-ийн ноос угаах үйлдвэрлэл нь төслийн зорилтот түвшинд хүрээгүй тул 2025 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хуваарилах санхүүгийн боломжгүй болохыг нийт хувьцаа эзэмшигч нарт мэдэгдсүгэй.

ДАРГА



Ц.ЗОРИГТ

Загвар

Баянхонгор аймгийн “Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Баянхонгор аймгийн “Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2026** оны **03**-р сарын 24-ний өдрийн **11.00** цагт хуралдана. **Хаяг** : ХУД. 1-р хороо. Чингисийн Өргөн Чөлөө. УБ-210136. “Улаанбаатар хивс” ХК-ийн байр.

1. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр –**2026 .03.02-ны өдөр.**
2. Хурлаар хэлэлцэх асуудал :
 - 2.1. “Стандарт ноос” ХК-ийн 2025 оны ерөнхий байдал, 2026 оны үндсэн зорилтын тухай
 - 2.2. “Стандарт ноос” ХК-ийн санхүүгийн тайлан, аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт
 - 2.3. “Стандарт ноос” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн сонгууль.
3. Хурлын материал, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичиг, гарах шийдвэрийн төслүүдтэй 2026.02.16-ноос эхлэн компани болон харилцагч брокер-дилерийн компаниуд дээр ажлын өдрүүдэд 10.00 – 17.00 цагт танилцаж болно. Саналын хуудсаар оролцох хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг компанийн захирлын туслах болон тооллогын комисс дээр биечлэн болон шуудангаар хүлээж авах сүүлчийн өдөр : 2026 .03.24-ний өдрийн 9.00.цаг хүртэл.
4. Хурал зохион байгуулах комиссын хаяг :

Комиссын дарга :утас : 70142556., 94941825, 99186624. e-mail : tsravdan@yahoo.com

Факс :11-343311, e-mail : ubcarpet@gmail.com

Web site : www.mongolia-carpet.mn

Эрхэм хувьцаа эзэмшигч Та бүхнийг хуралдаа хүрэлцэн ирж, идэвхитэй оролцохыг урьж байна.

**“Стандарт ноос” ХК-ийн хувьцаа
эзэмшигчдийн 2026 оны
хурлын саналын хуудас**

Компанийн нэр : **“Стандарт ноос” ХК**
Хурал хуралдах газар, өдөр, цаг : **“Улаанбаатар хивс” ХК-ийн хурлын
танхим,
2026.03.24-ний өдөр,
11.00 цаг.**

Хувьцаа эзэмшигчийн овог : нэр :
Регистрийн дугаар
Эзэмшиж буй хувьцааны төрөл /доогуур нь зурах/ : энгийн / давуу
эрхийн.
Эзэмшиж буй хувьцааны тоо : . . . ширхэг.
Бүртгэгдсэн : Брокерийн пүүсийн нэр, код :

Хурлын хэлэлцэн батлах асуудлууд:

1. “Стандарт ноос” ХК-ийн 2025 оны ерөнхий байдал,
2026 оны үндсэн зорилтын тухай

Зөвшөөрсөн

Татгалзсан

Түтгэлзсэн

2. “Стандарт ноос” ХК-ийн санхүүгийн тайлан, аудитын
байгууллагаас өгсөн дүгнэлт

Зөвшөөрсөн

Татгалзсан

Түтгэлзсэн

3. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигчид :
/Кумулятив аргаар санал өгнө/

.
.
.
.
.
.

Зөвшөөрсөн

Татгалзсан

Түтгэлзсэн

4. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдэд нэр дэвшигчид :
/Кумулятив аргаар санал өгнө/

.
.
.

Хурлаас гарах шийдвэрийг зөвшөөрсөн буюу татгалзсан товч утга :

.....
.....
.....

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

.....

2026 оны 3-р сарын ...-ны өдөр

Саналын хуудсыг бөглөх санамж

1. Хувьцаа эзэмшигч нь "Компанийн тухай хууль"-ийн 69.1-д заасны дагуу заавал биечлэн оролцох буюу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно. Хуралд оролцохоор ирэхдээ иргэний үнэмлэх, итгэмжлэлийг заавал авч ирнэ.
2. Хэрвээ саналын хуудсыг засварласан болон балласан, залруулга хийсэн, хоёрдмол утгатай бичигдсэн бол хуудас нь хүчингүйд тооцогдоно. Хуралд биеэр оролцогч нь саналын хуудсаа солих шаардлага гарвал хуралд оролцогч нарт биечлэн тайлбарлан танилцуулж саналын хуудсаа хайрцаганд хийхээс өмнө шинэ саналын хуудас авч болно.
3. Хэрэв та саналын хуудсаар оролцох бол саналын хуудсаа зохих ёсоор бөглөөд нотариатаар баталгаажуулан шуудангаар юмуу брокерийн пүүсээр эсвэл шууд компанид ирүүлж болно.
Хэрвээ таны саналын хуудас хурлын ирцийн бүртгэл дууссанаас хойш буюу 11.00 цагаас хойш ирвэл ирц болон санал хураалтын дүнд оруулахгүй.
4. Хэрэв брокерийн пүүсийн ажилтан харилцагч хувьцаа эзэмшигчээ төлөөлж хуралд оролцох, санал өгөх эрхтэй бол нотариатаар батлуулсан зохих итгэмжлэлийг саналын хуудасны хамт компанийн хурал зохион байгуулах комисст биечлэн авч ирнэ.
5. Саналын хуудасны асуудлуудад санал өгөхдөө арын дөрвөлжинд бичигдсэн хариултуудын зөвшөөрч буй хэсгээ дугуйлж санал өгнө. Хэрвээ таны өгөх саналтай бэлдсэн хариултууд тохирохгүй бол Та хурлаас гарах шийдвэрийг зөвшөөрсөн, татгалзсан товч тайлбарын хэсэгт саналаа бичиж болно.
6. ТУЗ-ийн гишүүдийн сонгуульд санал өгөхдөө хуулинд заагдсан кумулятив арга буюу Та өөрийн эзэмшиж буй хувьцааны тоог 9-өөр үржүүлсэнтэй тэнцүү хэмжээний саналыг өгөх эрх эдлэнэ. Үүнд ТУЗ-ийн ердийн гишүүдэд өгөх саналын тооны нийт нийлбэр нь таны хувьцааг 6-гаар үржүүлсэнтэй тэнцүү байх ба харин ТУЗ-ийн хараат бус гишүүдэд өгөх саналын тооны нийлбэр нь таны хувьцааг 3-аар үржүүлсэнтэй тэнцүү байна.
7. Санал өгөх үед ойлгомжгүй зүйл гарвал хурлын тэргүүлэгчид болон хурал зохион байгуулагч нарт хандан асууж болно. Бусад тохиолдолд "Улаанбаатар хивс" ХК-иас 99186624 дугаарын утсаар лавлаж болно.

Тооллогын комисс

“Стандарт ноос” ХК-ийн ТУЗ-ын хурлын протокол

Хурлын өдөр/ цаг : 2026.02.06. 14 цаг 00 минут

Хурлын ирц : Б.Батболд, Ц.Зоригт, З.Эрдэнээ , Л.Цэвээнравдан, Ё.Энхтөр, З.Мөнхмаа, Л.Цэндээхүү нар оролцож, хурлын ирц 77,8 % болж хурал хүчин төгөлдөр байх нөхцөл бүрдсэн. ТУЗ-ын гишүүн Б.Уранбилэг Баянхонгор аймагт ажилтай, Б.Баясгалан-томилолтоор явсан байв.

Ц.Зоригт : Хурлын ирц дүрмийн дагуу хангалттай байгаа тул хурлыг нээж, хэлэлцэх асуудлыг шууд танилцуулав. Үүнд :

Хурлаар хэлэлцэх асуудал :

1. “Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай: - Илтгэгч : Л.Цэвээнравдан., /Тогтоол гарна/
2. “Стандарт ноос” ХК-ийн ХЭХ-ын дарга, ирц бүртгэл-тооллогын комиссын томилох тухай: - Илтгэгч : Л.Цэвээнравдан., /Тогтоол гарна/
3. “Стандарт ноос” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны үр дүн, цаашдын зорилтын тухай товч танилцуулга
- Илтгэгч : Ц.Зоригт
5. Компанийн тухай хуулийн дагуу ногдол ашгийн талаар холбогдох шийдвэр гаргах тухай асуудал /Тогтоол гарна/

Хурлыг 14.00 - 16.00 цагт багтааж явуулахаар төлөвлөж байгааг танилцуулж 1-р асуудалдаа оров.

Л.Цэвээнравдан : Компанийн тухай хууль болон СЗХ-ны ХЭХурал хуралдуулах тухай журмын дагуу өнөөдрийн хэлэлцэх асуудлууд төлөвлөгдсөн. Тиймээс эхний асуудлын дагуу зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурал /ХЭХ/-ыг хуралдуулах тухай шийдвэрийн төсөл, төлөвлөгөөг танилцуулъя. Тухайлбал, Стандарт ноос ХК-ийн ХЭХ-ыг 2026.03.24-ний Мягмар гаригт 11 цагаас УБ хивс ХК-ийн компанийн хурлын танхимд хуралдуулахаар төлөвлөсөн. Хурлын хэлэлцэх асуудлуудад :

а/ “Стандарт ноос” ХК-ийн 2025 оны ерөнхий байдал, 2026 оны үндсэн зорилтын тухай

б/ “Стандарт ноос” ХК-ийн санхүүгийн тайлан, аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтийн тухай

в/ “Стандарт ноос” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн сонгууль гэсэн 3 асуудал хэлэлцэхээр төлөвлөж байна. Мөн “Стандарт ноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026.03.02-ны өдрөөр тогтоохоор санал оруулж байна. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд зарлан мэдэгдэх өдөр : 2026.02.11 ба 2026.02.26. Өдрийн сонин, Зууны мэдээ сонингуудад гаргана. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэж танилцуулна. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр : 2026.03.24-ний өдрийн 9.00.цаг байхаар тогтоож байгаа.

Ц.Зоригт : ТУЗ-ийн гишүүд бид ХЭХ хуралдуулах, зарлах үндсэн үүрэгтэй. Хурлын хугацаа, хэлэлцэх асуудалтай холбоотой зүйл байна уу. Миний хувьд ТУЗ-ийн гишүүдийн хувьд Б.Баясгалан болон Уранбилэг нар өөр ажилтай тул чөлөөлөгдөх санал гаргасан, иймд оронд нь Доржсамбуу, Баасанбат нарыг шинээр оруулах саналтай байгаа, бусад асуудлууд нь жил тутам хэлэлцдэг асуудал юм. Санал байна уу? Төлөвлөлтийг зөвшөөрөх үү?

Л.Цэвээнравдан : ТУЗ-ийн энэ өдрийн хурлын тогтоолын төслийг хавсралт 01-ийн хамт уншиж танилцуулав.

Санал гараагүй, бүгд зөвшөөрөв

Л.Цэвээнравдан : Компанийн тухай хуулийн 60.2.8., 60.2.9-р зүйл заалт, журмын дагуу ХЭХ-ын ирц бүртгэл, тооллогын комиссыг ТУЗ-аас хэлэлцэж батлах ёстой. Бас тухайн хурлын даргыг бид сонгох ёстой. Үүнтэй холбоотой 2-р тогтоол гарна.

Ц.Зоригт : Энэ удаагийн хурал удирдах даргаар Ё.Энхтөрийг томилох санал байна, бусад хүмүүсийн талаар санал байна уу?

3.Мөнхмаа : УБ хивсний Амаржаргал, Баясах, Соёлмаа нарыг тооллогын комиссын дарга, гишүүдэд оруулсан нь дээр байх, харин комиссын даргаар Б.Соёлмааг ажиллуулах нь зөв байхаа.

3.Эрдэнэ : Ажлыг нь зохицуулаад нэр дурьдсан хүмүүсийг ажиллуулахыг дэмжиж байна.

Бүгд дэмжиж, тооллогын комиссын дарга, гишүүдийн тухай 2-р тогтоолыг батлав.

Л.Цэвээнравдан : ХЭХ-ын саналын хуудасны загварыг бол урьдын хэрэглэж байсан загвараар хийхээр төлөвлөсөн байгаа, гэхдээ ТУЗ-ын хараат ба энгийн гишүүдийн нэр оруулах болно. ТУЗ-ийн даргын зүгээс санал болгосон хуучин 7 гишүүн болон шинэ 2 хүний анкет, танмилцуулгыг авч нэрсүүдийг нь саналын хуудсанд оруулна. Одоогоор саналын хуудасны загварыг СЗХ, МХБ-д илгээнэ.

Өөр санал гараагүй тул Ц.Зоригт дарга саналын хуудасны загварыг батлуулав.

Ц.Зоригт : УБ хивс ХК-ийн зүгээс төсөл хэрэгжүүлэхэд нөөц бололцоондоо тулгуурлан жил тутам анхаарч, ажил хийж ирсэн. Өнгөрсөн жил үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдлэх, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, ашиглалт, засвар үйлчилгээний ажлыг хэвшүүлэх, ноос угаах зорилтот түвшинд хүргэхэд шаардлага хангахгүй байгаа зүйлүүдэд анхаарч, үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэх техник, тоног төхөөрөмжийн судалгаа, арга туршлагыг гадаад дотоодгүй нилээдгүй судалсан. Үүний үр дүнд 400 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2026 онд хийхээр төлөвлөж байгаа. Өнгөрсөн онд Стандарт ноос ХК-ийн ноос угаах үйлдвэр нь 2024 оны 8-р сард ашиглалтанд орсон бөгөөд 2024 онд 45,08 тн., 2025 онд 56,75 тн., угаасан ноосыг “Улаанбаатар хивс” ХК-д нийлүүлсэн байна. Компанийн бусад үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн хараахан гараагүй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл хангах явцад тайлан гарч танилцуулагдах болно. Харин 3-р асуудал буюу ногдол ашиг хуваарилах тухайд бол үйлдвэрлэл, үйл ажиллагаа, санхүүгийн боломжийн хувьд ногдол ашиг хуваарилах боломж байхгүй тул хувьцаа эзэмшигч нартаа энэ тухай мэдэгдэх үүрэгтэй, энэ тухай тогтоолын төслийг батлах уу.

Бүгд зөвшөөрч гар өргөв.

Ц.Зоригт : Хэлэлцэх асуудал үүгээр дуусаж байна. Хурлын шийдвэр тогтоолууд гарна. Одоо хувьцаа эзэмшигчдийн хуралдаа сайн бэлтгэж, тайлан тооцоо, танилцуулгаа сайн бэлдэх хэрэгтэй. Хурлаа хааж байна. Идэвхитэй оролцсон та бүхэнд баярлалаа.

Хурал 15.30-д дуусав.

Хянасан : ТУЗ-ийн дарга :



Ц.Зоригт

Протокол хөтөлсөн : ТУЗ-ийн нбд

Л.Цэвээнравдан